# ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний барааны үнийн 2018 оны*
*Х сарын 31-ний өдрийн ажиглалт*

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 33 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2018 оны X сарын 5-р долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 22 нэрийн барааны үнэ тогтвортой, 1 нэрийн барааны үнэ буурсан, 10 нэрийн барааны үнэ өссөн байна. Үүнд :

≈ Үнэ тогтвортой

- "Алтан Тариа" задгай гурил дээд
- "Алтан Тариа" задгай гурил I
- "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд
- "Алтан Тариа" савласан гурил дээд
- "Алтан Тариа" савласан гурил I
- "Алтан Тариа" савласан гурил II
- "Алейка" гурил дээд
- “Сүү” ХК хайрцагтай 1 л сүү
- Тараг, Цөцгийтэй
- Талх, "Атар"
- Талх, “Зууван чех”
- Талх, “хөх талианы хар”
- Цагаан будаа
- Ургамлын тос, “Янта”
- Ногоон цай, “Стимо”
- Элсэн чихэр
- Адууны мах, ястай
- Байцай, монгол
- Хүрэн манжин, монгол
- Сонгино, хятад, бөөрөнхий
- Алим, фужи
- Өндөг, ОХУ

⇩ Үнэ буурсан

- Шар будаа

⇧ Үнэ өссөн

- “Сүү” ХК савласан 0.5 л сүү
- Сүү, задгай
- Цөцгийн тос, Сүү ХК
- Хонины мах, ястай
- Хонины мах, цул
- Үхрийн мах, ястай
- Үхрийн мах, цул
- Ямааны мах, ястай
- Төмс, монгол
- Лууван, монгол

## Махны дундаж үнэ

2018 оны X сарын 5-р долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 6780 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 8035 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 55 төгрөгөөр (0.7%), үхрийн цул махны үнэ 100 төгрөгөөр (1.1%) тус тус өссөн байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 7200 төгрөг, Харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 8800 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

**Үхрийн ястай мах**

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 7 335 | 8 025 | 7 895 | 8 330 | 8 380 | 8 275 | 8 225 | 7 710 | 7 825 | 7 245 | 7 115 | 7 280 |
| 2014 | 7 980 | 7 775 | 8 425 | 8 370 | 8 685 | 8 730 | 7 955 | 7 590 | 7 635 | 7 550 | 7 495 | 7 465 |
| 2015 | 7 415 | 7 565 | 7 810 | 8 080 | 8 145 | 8 445 | 7 985 | 7 230 | 7 005 | 5 975 | 5 620 | 5 520 |
| 2016 | 6 165 | 6 875 | 7 105 | 8 170 | 8 495 | 7 930 | 6 950 | 6 865 | 6 120 | 5 235 | 5 495 | 5 580 |
| 2017 | 6 775 | 7 405 | 7 785 | 7 985 | 8 230 | 7 905 | 7 725 | 7 375 | 7 250 | 6 945 | 6 710 | 6 505 |
| 2018 | 6 615 | 7 110 | 7 740 | 8 365 | 8 465 | 8 735 | 9 085 | 8 225 | 7 780 | 8035* | | |

**Хонины ястай мах**

| | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2013 | 6 480 | 7 095 | 7 060 | 7 420 | 7 490 | 7 470 | 7 415 | 6 710 | 6 540 | 6 215 | 6 085 | 6 245 |
| 2014 | 6 855 | 6 675 | 7 040 | 7 630 | 7 800 | 7 685 | 7 030 | 6 585 | 6 395 | 5 965 | 5 835 | 5 940 |
| 2015 | 5 860 | 6 140 | 6 735 | 7 460 | 7 555 | 7 455 | 6 830 | 6 050 | 5 540 | 4 510 | 4 200 | 3 930 |
| 2016 | 4 625 | 5 495 | 5 970 | 6 935 | 6 945 | 6 525 | 5 780 | 5 605 | 4 940 | 4 250 | 3 945 | 4 390 |
| 2017 | 5 650 | 6 030 | 6 675 | 7 080 | 7 235 | 6 700 | 6 575 | 6 395 | 6 210 | 5 760 | 5 380 | 5 140 |
| 2018 | 5 240 | 5 945 | 6 560 | 7 290 | 7 490 | 7 515 | 7 535 | 6 980 | 6 415 | 6780* | | |

* 5-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг




Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 200 төгрөгөөр (3.0%), хонины цул махны үнэ 115 төгрөгөөр (1.7%) өссөн байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины мах “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад хамгийн хямд буюу 6000 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 8000 төгрөгөөр худалдаалж байна.

## Гурилын үнэ



2018 оны X сарын 5-р долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1250-1500 төгрөг, 1-р зэргийнх 950-1200 төгрөг, 2-р зэргийнх 800-1000 төгрөг байна.

Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1250-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1250 төгрөг, 1-р зэргийн гурил 950 төгрөгөөр тус тус зарагдаж байна.

Зураг 3. Дээд зэргийн гурилын үнэ, 1 кг




Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг







“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1100-1210 төгрөгийн үнэтэй байна. “Бөмбөгөр”, “Оргил”, “Хүчит Шонхор”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1100 төгрөгөөр, харин “Сансар” супермаркетад хамгийн өндөр үнээр буюу 1210 төгрөгөөр худалдаалж байна.

## Хүнсний ногооны үнэ

2018 оны X сарын 5-р долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 6.3 хувиар өсөж 845 төгрөгөөр, лууван 2.8 хувиар өсөж 1115 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг




## Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2018.X.31

Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны VIII, IX, X сар

Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2012-2018 оны X сарын 31

Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2018.X.31

Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2018 оны VIII, IX, X сарын ажиглалтаар

Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2018 он

Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2018.X.31